



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/50

Улаанбаатар хот

Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн
үед ажиллах мэргэжлийн баг томилох тухай

Дархлаажуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.9, 5.2 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2012 оны 217, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 504, 2016 оны А/278, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/527 дугаар тушаалуудыг үндэслэн ТУШААХ нь:


1. Сэргийлэх тарилга /дархлаажуулалт/-ын дараах урвал, хүндрэлийн шалтгаан хамаарлыг тогтоох, мэргэжлийн багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажиллах журмыг хоёр дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Багийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Хүүхдийн ерөнхий зохицуулагч /Т.Энхээ/-д үүрэг болгосугай.
3. Энэ тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалыг ЭТҮЧА-ны менежер /Ц.Оюунчимэг /-д даалгасугай.

ДАРГА

Э.БОДЬЦЭЦЭГ



Хан-Уул эрүүл мэндийн төвийн даргын
2020 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн
#150 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



Дархлаажуулалтын дараах урвал,
хүндрэлийн тохиолдлын үед ажиллах мэргэжлийн
багийн бүрэлдэхүүн

Багийн ахлагч:
Гишүүд:

Хүүхэд өсвөр үеийн ерөнхий зохицуулагч
ЭТҮЧАлба
Өрхийн менежер
Дархлаажуулалт хариуцсан тархвар судлаач
Хүүхдийн эмч
Мэдрэлийн эмч
Клиник лабораторийн эмч
Мэс заслын эмч

Хан-Уул эрүүл мэндийн төвийн даргын
2020 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн
#150 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

СЭРГИЙЛЭХ ТАРИЛГА /ДАРХЛААЖУУЛАЛТ/-ЫН ДАРААХ УРВАЛ,
ХҮНДРЭЛИЙН ШАЛТГААН ХАМААРЛЫГ ТОГТООХ,
МЭРГЭЖЛИЙН БАГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Дархлаажуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.9, 5.2 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2012 оны 217, Эрүүл мэнд спортын сайдын 2015 оны 504, 2016 оны А/278, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/527 дугаар тушаалуудын хэрэгжилтийг ханган дархлаажуулалтын улмаас хүний эрүүл мэндэд учирсан тогтвортой эсхүл ноцтой хямралд шалтгаан-хамаарлын үнэлгээ хийх, дүгнэлт гарган баталгаажуулахад Журмыг хэрэгжүүлнэ.

Хоёр. Багийн ажил үүргийн чиглэл

2.1 Дархлаажуулалтын дараах урвал хүндрэл гарсан тохиолдолд багийн гишүүдийг 2 цагийн дотор цуглуулан хуралдуулж урвал хүндрэл (Дархлаажуулалтын дараах урвал хүндрэл)-ийн тохиолдол бүрийн шалтгаан хамаарлын үнэлгээг хянан хэлэлцэж, дүгнэлт гаргах

2.2 Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тандалтын явцтай танилцан мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх

2.3 Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тохиолдлын шалтгаан хамаарлын үнэлгээг хийх

2.4 Дүүргийн хэмжээнд дархлаажуулалтын дараах урвал хүндрэлээс сэргийлэх болон дархлаажуулалтын дараах урвал хүндрэл бүртгэгдсэн тохиолдолд тандалтыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр ханган, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулах

2.5 Мэргэжлийн баг нь дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тохиолдлын шалтгааныг тогтоох зорилгоор дархлаажуулалттай холбоотой бүх үйл ажиллагааг хянаж нарийвчилсан судалгааг ажлын 3 хоногт багтаан хийж, эхний дүгнэлтийн харьяа дүүрэг, нийслэлийн мэргэжлийн хяналтын байцаагчид хүргүүлж дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн сэжигтэй тохиолдлыг магадлан тогтоолгох

2.6 Мэргэжлийн баг нь дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн сэжигтэй өвчтөнг шаардлагатай тохиолдолд дараагийн шатны эмнэлэгт шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх

2.7 Цаг хугацаа газар зүйн адил байрлалд нэг төрлийн вакцин тариулсан, ижил шинж тэмдэгтэй дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн сэжигтэй тохиолдолд байгаа эсэхийг илрүүлэх идэвхитэй тандалтыг зохион байгуулах

Гурав. Үйл ажиллагааны тайлан мэдээг гаргах, тайлагнах

3.1 Чанарын багийн хурлын тэмдэглэлийг баримтжуулан архивлах

3.2 Эрүүл мэндийн сайдын 2012 оны 274 дугаар тушаалын дагуу алдаа зөрчлийг бүртгэх

3.3 Дүүргийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн хүлээн авсан дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн мэдээллийг НЭМГ-ын дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд утсаар болон цахимаар өгөх

3.4 Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тохиолдол бүрт судалгаа хийж судалгааны үр дүнг тухайн урвал хүндрэл илэрсэн нэгж, Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвд хүргүүлж тайлагнан, Эрүүл мэндийн төвийн архивт хадгалуулах

3.5 Вакцин зүү тариурын сорьц, өвчтөнөөс авсан шинжлэгдэхүүнд лабораторийн шинжилгээ хийлгэж, хариуг албан ёсоор Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвд хүргүүлэх

Дөрөв. Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн багийг дараах тохиолдолд зарлан хуралдуулна:

4.1 Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тандалтаар хүнд хэлбэрийн урвал, хүндрэл илэрсэн үед

4.2 Иргэд, албан байгууллагийн гаргасан хүсэлтийн дагуу

4.3 Шаардлагатай бусад тохиолдлуудад